



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар A/630

Улаанбаатар хот


┌ МУИС-ийн шинжлэх ухаан технологийн ┐
Улаанбаатар паркийн журам
батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.2, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь заалт, МУИС-ийн Ректорын зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 26 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн шинжлэх ухаан технологийн Улаанбаатар паркийн журмыг хавсралтаар баталж, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (С.Гомбобаатар), Төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор (Б.Даваасүрэн), МУИС-ийн шинжлэх ухаан технологийн Улаанбаатар паркийн захирал (О.Мөнхбат) нарт даалгасугай.


РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

1425065406

Монгол Улсын Их Сургуулийн ректорын
2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн
1/630 дугаар тушаалын хавсралт



МУИС-ИЙН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН УЛААНБААТАР ПАРКИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухаан Технологийн Улаанбаатар Парк (цаашид “Парк” гэх)-ийн удирдлага, бүтэц зохион байгуулалт, санхүүжилт, сургалт, судалгаа, инновацыг түгээн дэлгэрүүлэх үндсэн үйл ажиллагааг зохицуулахад уг журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмыг Инновацын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль болон Монгол Улсын холбогдох бусад хууль, тогтоомж, МУИС-ийн Дүрэм, МУИС-ийн Стратеги төлөвлөгөө, Технологи дамжуулах журам зэрэгт нийцүүлэн паркийн үйл ажиллагаанд дагаж мөрдөгдөнө.

1.3. Парк нь Улаанбаатар хотод байрлана. Албан ёсны хаяг: Монгол Улс. Улаанбаатар хот 13343, Баянзүрх дүүрэг, 41-р хороо, Г.Лувсанцэвээний гудамж, МУИС-ийн Шинжлэх ухаан технологийн Улаанбаатар парк. Утас: 7575-4400 (5301, 5302).

1.4. Байгууллагын товчилсон нэр: МУИС-ийн ШУТУБП; англи нэр: Ulaanbaatar Science Technology Park of the National University of Mongolia; орчуулгын товчлол: UBSTP, NUM; цахим хуудас: <https://ubstp.num.edu.mn>.

1.5. Парк нь холбогдох хууль, журмын дагуу үйлдэж, оюуны өмчийн эрхээр баталгаажуулсан албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, бэлгэдэл (лого, туг)-тэй байна.

ХОЁР. ЖУРМЫН НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Инновац” гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга шийдлийг;

2.1.2. “Технологи дамжуулах” гэж технологи эзэмшигч өөрийн технологийг ашиглах эрхийг бусад иргэн, хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлэх үйл ажиллагааны цогцолборыг;

- 2.1.3. “Технологийн туршилт-зүгшрүүлэлт” гэж лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийх үйл ажиллагааг;
- 2.1.4. “Инновацын экосистем” гэж төр, хувийн хэвшил, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, бизнес бойжуулагч, хурдасгагч, хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх, инновацын үйл ажиллагааг үр ашигтай явуулах таатай орчныг;
- 2.1.5. “Роялти” гэж оюуны өмчийг лицензийн гэрээгээр ашиглан, олсон ашгаас лиценз түрээслүүлэгчид ногдох хувь хэмжээг хэлнэ.
- 2.1.6. “Төв” гэж паркийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийн нэгжийг хэлнэ.

ГУРАВ. ПАРКИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

3.1. МУИС-ийн төсөв, түүний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татна.

3.2. Их сургуулийн багш, судлаач, суралцагчдын инновацыг түгээн дэлгэрүүлэх, төр - их сургууль - хувийн хэвшлийн гуравласан хамтын ажиллагааг өргөжүүлэх, технологийн туршилт-зүгшрүүлэлт хийх, технологи дамжуулах, судалгааны үр дүнг нэмүү өртөг шингэсэн арилжааны бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилготой судалгаа, туршилт үйлдвэрлэл, сургалт, танин мэдэхүй, соён гэгээрүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

3.3. МУИС-ийн багш, судлаач, суралцагчдын боловсруулсан технологийг инновацын бүтээгдэхүүн болгох, гарааны компани байгуулахад шаардлагатай технологи зүгшрүүлэлт, туршилт үйлдвэрлэл, бизнес, маркетингийг хөгжүүлнэ.

3.4. Судлаачдын боловсруулсан технологийг сайжруулах, оюуны өмчийг хамгаалах, байгаль орчинд ээлтэй, өндөр технологийг дамжуулж, нутагшуулна.

3.5. Технологийн туршилт-зүгшрүүлэлтийн судалгааг “Технологийн туршилт-үйлдвэрлэлийн цехийн дотоод журам”-аар зохицуулна.

3.6. Технологи дамжуулах, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг МУИС-ийн “Технологи дамжуулах журам”-аар зохицуулна.

3.7. Шинжлэх ухаан технологи, инновацын чиглэлээр гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлж, үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

3.8. МУИС-ийн оюуны өмчийг лицензийн гэрээгээр баталгаажуулах, арилжаалах түүнээс олох роялти ашгийг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.9. Инновац, шинжлэх ухаан технологийн сүлжээг бий болгож, хамтын оффис хөгжүүлнэ.


3.10. Зэргийн бус урт, богино хугацааны сургалтын үйл ажиллагаа, сургалт-үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулна.

3.11. МУИС-ийн багш, судлаачдын эрдэм шинжилгээ, инновацын бүтээлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний хурал, сэтгүүл, ном бүтээл эрхлэх болон бусад хэлбэрээр гаргана.

3.12. МУИС-ийн судалгаа, сургалтын дэд бүтцийн бүрдэл хэсгийн нэг болох инновацын экосистемийг төлөвшүүлэн хөгжүүлнэ.

3.13. Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн инновацыг хөгжүүлэх төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, инновац, оюуны өмч, судалгааны орчны эрх зүйн чадамжийг сайжруулахад санал санаачилга гаргана.

3.14. МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургуулиуд болон төрийн өмчийн их сургуулиуд, ШУА, гадаадын их сургуулиудтай хамтарсан, салбар дундын ахисан түвшний хөтөлбөр боловсруулах, зохион байгуулахыг дэмжиж ажиллана.



ДӨРӨВ. ПАРКИЙН БҮТЭЦ

4.1. Парк нь хэвийн, тогтвортой үйл ажиллагаа явуулах инновацын экосистемийн хэрэгцээ шаардлагыг хангах зохион байгуулалт, бүтэцтэй байна:

4.1.1. Технологи, инновацын төв

4.1.2. Технологийн зүгшрүүлэлт, туршилт-үйлдвэрлэлийн төв

4.1.3. Гэрлаб инженерийн төв

4.1.4. Сургалт, шинжилгээний лаборатори

4.2. Технологи, инновацын төв нь МУИС-д бий болсон судалгаа, шинжилгээний үр дүн, технологи, инновац шингэсэн оюуны өмчийг үр ашигтай, хүртээмжтэй байдлаар нийтэд ашиглуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээрт суурилсан гарааны компаниудыг үүсгэх, хөгжүүлэлтийн дараагийн шатанд шилжүүлэх чиг үүрэгтэй. Тус төв нь төсөл, хөтөлбөрийн үр дүнд шинээр бүтээж, хөгжүүлсэн технологи, инновацыг эзэмших, ашиглах, шилжүүлэх эрхтэй холбоо бүхий харилцааг зохицуулах, шинжлэх ухааны мэдлэг технологи дамжуулалт, эргэлтэд оруулж бий болсон үр өгөөжийг шударгаар хуваарилахтай холбогдсон харилцааг холбогдох хууль, журам, бодлогын хүрээнд зохион байгуулна.


4.3. Технологийн зүгшрүүлэлт туршилт-үйлдвэрлэлийн төв нь лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн зүгшрүүлэлт хийх, туршилт-үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлнэ.

4.4. Гэр лаб инженерийн төв нь сургалтын лабораториудын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, дизайн зураглал хийх болон бусад орлого олох үйл ажиллагаа эрхэлнэ.

4.5. Сургалт, шинжилгээний лаборатори нь парк, технологийн зүгшрүүлэлт, туршилт-үйлдвэрлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт болон бусад захиалгат төлбөртэй шинжилгээг хийж гүйцэтгэнэ.

4.6. Парк нь дэргэдээ судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн дадлагын үйл ажиллагааг явуулах түшиц бааз мөн чанарын алба, соёл, технологийн болон робот дрон, нисэх, хиймэл оюун ухаан зэрэг урлан, платформтой байж болно.

ТАВ. ПАРКИЙН УДИРДЛАГА



5.1. Удирдлагын тогтолцоо

5.1.1. Монгол Улсын Боловсролын тухай хууль, Инновацын хуулийн 20.1, МУИС-ийн дүрэм, Удирдах зөвлөлийн тогтоолын дагуу паркийн удирдлага нь Инновац, технологийн зөвлөл, Эрдмийн зөвлөл болон гүйцэтгэх удирдлагаас бүрдэнэ.

5.1.2. Паркийн удирдлага энэ журмаар тодорхойлсон эрх, үүрэгтэй байна.

5.2. Инновац, технологийн зөвлөл (цаашид “ИТЗ” гэнэ)

5.2.1. ИТЗ нь 9 гишүүнээс бүрдэх ба паркийн зөвлөлийн гишүүдийн 20 хүртэлх хувь нь МУИС-ийн төлөөлөл байна:

- Төр, орон нутгийн засаг захиргаа - 2 (Засгийн газар, яам, хэрэгжүүлэгч агентлаг)
- Монгол Улсын Шинжлэх Ухааны Паркийн захиргаа - 1
- Эрдэм шинжилгээний байгууллага - 2 (МУИС-ийн судалгааны хүрээлэн, төв, ШУА-ийн хүрээлэнгүүд)
- МУИС-ийн ШУТУБП - 2
- Хувийн хэвшил, бизнес эрхлэгчдийн төлөөлөл - 2.

5.2.2. ИТЗ-ийг 3 жил тутамд шинэчлэн байгуулах бөгөөд МУИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.

5.2.2.1. ИТЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь ИТЗ-ийн хуралдаан байна. Хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа явуулна. ИТЗ-ийн гишүүдийн 1/3-ийн хүсэлтээр, мөн цаг үеийн шаардлагаар ээлжит бус хурал зохион байгуулж болно.

5.2.2.2. ИТЗ-ийн нийт гишүүдийн 75%-аас доошгүй ирц бүрэлдсэн тохиолдолд хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.

5.2.3. ИТЗ-ийн дарга, нарийн бичгийн даргыг ИТЗ-ийн хурлаас ил санал хураалтаар сонгоно.

5.2.4. ИТЗ нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 5.2.4.1. Паркийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөг хэлэлцэн батлах, өөрчлөх, дүгнэх;
- 5.2.4.2. Үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах;
- 5.2.4.3. Үйл ажиллагааны тайланг жил бүр хэлэлцэж дүгнэлт гаргах;
- 5.2.4.4. Үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд үндэсний болон гадаадын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх, хяналт тавих, үр дүнг хэлэлцэх үүрэгтэй.

5.3. Эрдмийн зөвлөл

5.3.1. Эрдмийн зөвлөл нь МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургуулиудын докторын зэрэгтэй багш нар болон паркийн 7-оос доошгүй төлөөллөөс бүрдэх ба зөвлөлийн дарга, эрдэмтэн нарийн бичгийн даргатай байна. Паркийн төлөөллийн 4 гишүүнийг паркийн эрдмийн зэрэгтэй нийт ажилтан, мэргэжилтнүүдийн нууц санал хураалтаар, бусад 3 гишүүнийг МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургуулиудын Эрдмийн

зөвлөлийн даргатай зөвшилцөн бүрдүүлнэ. Эрдэмтэн нарийн бичгийн даргыг зөвлөлийн хурлаас ил санал хураалтаар 3 жилийн хугацаатай сонгоно.

5.3.2. Паркийн захирал нь Эрдмийн зөвлөлийн дарга байна.

5.3.3. Эрдмийн зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг гүйцэтгэнэ:

- 5.3.3.1. Паркийн эрдэм шинжилгээ судалгаа, сургалтын бодлогыг тодорхойлох, судалгааны төсөл, хөтөлбөрийн санал дэвшүүлэх, гүйцэтгэлийн үр дүнгийн тайлан хэлэлцэх, дүгнэлт гаргах;
- 5.3.3.2. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийг хэлэлцэх, дүгнэлт гаргах;
- 5.3.3.3. Паркийн цех, төвийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм журам, стандарт батлах;
- 5.3.3.4. Паркийн хүндэт доктор цол, хүндэтгэл олгоно.

5.4. Захирал

5.4.1. Паркийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

5.4.2. Паркийн захирлыг судлан шалгаруулах үйл явцыг МУИС-ийн Дүрмийн 5.5.3.1-ээс 5.5.3.2-д заасны дагуу зохион байгуулна.

5.4.3. Паркийн захирал нь 3 жилийн хугацаатай томилогдох бөгөөд Ректор ажлаа тайлагнана. Захирлын ажлыг хангалттай гэж Ректор үзсэн тохиолдолд 1 удаа үргэлжлүүлэн ажиллуулж болно.

5.5. Паркийн захирал нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.5.1. Судалгааны ажлын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөр, захиалгат, гэрээт ажлын тоо, чанарыг сайжруулах, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, олон нийтэд сурталчлах, судалгаа, үйлдвэрлэлийн ажлын нэгдлийг хангах;

5.5.2. МУИС-ийн захирлаас шилжүүлсэн эрхийн хүрээнд паркийн санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, ил тод мэдээлэх, олон эх үүсвэрт санхүүгийн тогтолцоог бий болгох, материаллаг баазыг бэхжүүлэх, багш, судлаач, ажилтан, суралцагчдын ажиллах, суралцах таатай орчныг бүрдүүлэх;

5.5.3. Паркийг төлөөлж гадаад, дотоодын төр- их сургууль - хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, лицензийн болон роялти хуваах гэрээ байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулах;

5.5.4. Паркийн лаборатори, төв болон бусад нэгжийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, тэдгээрийн удирдлагыг томилох, өөрчлөх асуудлаар МУИС-ийн захиралд санал оруулах;

5.5.5. Паркийн үйл ажиллагааны ашиг орлогоос паркийн мэргэжилтэн, ажилтан, ажилтнуудад нэмэгдэл цалин, урамшуулал олгох;

5.5.6. Паркийн багш, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээг цуцлах, чөлөө олгох, үргэлжлүүлэн ажиллуулах саналыг МУИС-ийн захиргаанд уламжлах зэрэг болно.

5.6. Захирал эрх, үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй паркийн захиргааны зөвлөлийг ажиллуулна.

5.7. Захиргааны зөвлөл нь захирал, төв, лабораторийн эрхлэгч, нягтлан бодогч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

5.8. Төвийн эрхлэгч

5.8.1. Төвийн эрхлэгч нь магистр, түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, хариуцан буй төвийн үйл ажиллагаа, судалгаа, шинжилгээний ажлын туршлагатай.

5.8.2. Эрхлэгчийг паркийн захирлын санал болгосноор МУИС-ийн ректор 3 жилийн хугацаатай томилох бөгөөд нэг удаа улиран ажиллуулж болно.

5.8.3. Эрхлэгч нь эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл болон МУИС-ийн профессор, дэд профессор цолтой бол судалгааны суурь зардал авна.

5.8.4. Эрхлэгч нь захиргааны зөвлөлийн гишүүн байна.

5.8.5. Ажилтан, мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа, ёс зүйн байдалд дүгнэлт өгөх, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох талаар паркийн удирдлагад санал оруулна.

5.8.6. Эрхлэгч нь паркийн захиралд ажлаа тайлагнах бөгөөд дараах чиг үүрэгтэй:

5.8.6.1. Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг үр дүнд суурилсан, хариуцлагатай удирдан зохион байгуулах, тайлагнах, мэргэжилтэн, ажилтны ажлыг чиглүүлж, үр дүнг үнэлэн дүгнэнэ.

5.8.6.2 Төвийн чиг үүргийн хүрээнд төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх, санхүүжилт татна.

5.8.6.3 Гуравласан хамтын ажиллагааг дэмжиж, талуудтай гэрээ хэлцэл байгуулах санал оруулж, шийдвэрлүүлнэ.

5.8.6.4 Мэргэжилтнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд жигд оролцох боломжоор хангана.

5.8.6.5 Паркийн тохижилт, дэд бүтцийн хөгжүүлэлт, ашиглалтыг сайжруулж, нэмэгдүүлнэ.


5.8.6.6 Паркийн төсөв бүрдүүлэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт татна.

ЗУРГАА. ПАРКИЙН МЭРГЭЖИЛТЭН

6.1. Паркийн мэргэжилтэн нь МУИС-ийн Дүрмийн 7-д заасан эрх, үүрэгтэй.

6.2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, технологи, инновацын бүтээгдэхүүн, оюуны өмчийг эргэлтэд оруулахтай холбоотой үйл ажиллагааг МУИС-ийн дотоод дүрэм, журамд нийцүүлэн, зохиогчийн эрх, эдийн засгийн үнэ цэн, үнэлгээг үнэн бодитой үнэлэн гуравласан хамтын ажиллагааг дэмжин ажиллана.

6.3. МУИС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүдэд мэргэжсэн чиглэлээрээ нэг улиралд 3 багц цагаас илүүгүй хичээл зааж болно.



6.4. Эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл авна.

6.5. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ цаг тухайд нь бүрэн биелүүлж, хийсэн ажлаа тайлагнах, МУИС-ийн дүрэм журмын дагуу дурдсан хугацаанд аттестатчлалд орно.

6.6. МУИС-ийн журам, хөдөлмөрийн гэрээгээр тогтоосон ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаж, ажил үүргээ биелүүлэхэд бүрэн зарцуулна.

6.7. Паркийн үндсэн чиг үүргийн хүрээнд төсөл, хөтөлбөр санаачилж хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт татахад санаачилга, идэвх зүтгэл гаргана.

ДОЛОО. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

7.1. Паркийн үндсэн чиг үүрэг, хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан урт, богино хугацааны зорилго, зорилтын хүрээнд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах, ил тод хариуцлагатай, санхүү төсвийн зохистой үйл ажиллагааг явуулна.

7.2. Паркийн санхүүжилт нь дараах эрх үүсвэрээс бүрдэнэ:

7.2.1. МУИС-ийн санхүүжилт, хөрөнгө оруулалт;

7.2.2. МУИС-ийн дүрэм, журамд заасан эрдэм шинжилгээний төсөл, гэрээт болон захиалгат ажлын судалгааны санхүүжилтийн шимтгэл;

7.2.3. Парк дээр байрлаж, үйл ажиллагаа явуулж буй МУИС-ийн харьяа судалгааны хүрээлэн, төв, лабораторийн хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн холбогдох журам, эрх зүйн баримтын шийдвэрлэсэн шимтгэл;

7.2.4. Дундын оффис зэрэг паркийн дэд бүтцийн байр талбай, тоног төхөөрөмжийн түрээс, үйлчилгээний орлого, хураамж;

7.2.5. Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны санхүүжилт;

7.2.6. Улс, аймаг, хот, дүүргийн засаг захиргааны захиалгат ажлын санхүүжилт;

7.2.7. Технологи дамжуулалт, Оюуны өмчөөс олох орлого;

7.2.8. Урт, богино хугацааны захиалгат болон бусад сургалтын төлбөр;

7.2.9. Зохих журмын дагуу аж ахуй нэгж байгууллага, иргэд, төгсөгчдөөс өгсөн хандив, тусламжийн орлого;

7.2.10. МУИС-ийн Эндаументын сан;

7.2.11. Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.